



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2021 оны 3 сарын 11 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.19 дэх хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 22 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналтын тооллого хийх нийтлэг журам”-ын 2, 3 дугаар бүлэгт дор дурдсан агуулгатай 2.6, 3.8, 3.9 дэх хэсгийг нэмсүгэй:

“2.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухайд 100 хувь хяналтын тооллого хийх бөгөөд хяналтын тооллого хийгдэх хэсгийг сонгох зохицуулалт хамаарахгүй.

3.8. Хяналтын тооллогын ажиллагааг зохион байгуулагчид буюу хэсгийн хорооны гишүүд нэг удаагийн зориулалт бүхий бээлий, богино ханцуйтай цамц өмссөн байна. Хяналтын тооллого хийх хугацаанд гартаа бугуйвч, бөгж, зүүлт, цаг зэрэг эд зүйл хэрэглэхийг хориглоно.

3.9. Хяналтын тооллогын үйл ажиллагааг бүхэлд нь хяналтын камерт буулгаж баталгаажуулна.”

2. Мөн журмын 3.1 д хэсгийг “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.5.2-т заасны дагуу хийгдсэн тооцоог ажиглагч болон бусад оролцогчид мэдээлэл хийсний дараа хяналтын тооллогыг нэн даруй эхлүүлж, завсарлагагүйгээр явуулж дуусгана.” гэж өөрчлөн найруулсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000055